



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ



МОНЭС

МОНГОЛЫН ЭМЭРТЭЙЧҮҮДИЙН САЯ



# ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ӨРТӨГ

судалгааны хураангуй



# ГЭР БҮЛИЙН ХУЧИРХИЙЛЛИЙН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ӨРТӨГ

— /Судалгааны хураангуй/

Улаанбаатар хот  
2009 он

**Судлаачдын баг:**

Т.Бүрэнжаргал  
С.Нарантуяа  
Д.Оюунцэцэг  
Г.Түмэннаст

**Зөвлөх:**

Д.Энхжаргал

# ОРШИЛ

“Гэр бүлийн хүчирхийллийн нийгэм-эдийн засгийн өртөг” сэдэвт эл судалгааг UNESCO-ийн санхүүжилтээр Монголын эмэгтэйчүүдийн сангийн /МОНЭС/ дэмжлэгтэйгээр МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн судлаачдын баг 2007 онд хийсэн юм.

Гэр бүлийн хүчирхийлэл нь социалист нийгэмд гэр бүлийн дотоод хэрэг, хувийн асуудал гэж үзэгддэгээс далд, нуугдмал оршиж байсан бол зах зээлийн чөлөөт нийгэмд гэр бүлийн хүрээнээс хальж, нийгмийн асуудал болох нь хүлээн зөвшөөрөгдөж, төрийн зохицуулалт шаардагдах болтлоо ил гарч, олон тооны таагүй үр дагаврыг авчирч байна. Хэдийгээр гэр бүлийн хүчирхийллийг ялгаварлан гадуурхалтын ноцтой хэлбэр, хүний суурь эрхийн зөрчил гэдгийг олон нийт, шийдвэр гаргагчид ойлгож эхэлсэн ч гэмт хэрэг гэдгийг нь одоогоор хүлээн зөвшөөрч чадаагүй л байна. Энэ нь гэр бүл дэх хүчирхийллийн улмаас хувь хүн, гэр бүл, улмаар нийгэмд учруулж байгаа үр дагаврыг гүйцэд танин мэдээгүй байгаатай тодорхой хэмжээгээр холбоотой байна. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн чиглэлээр судалгаа хийгдэж, олон чухал зөвлөмж гарсан байдаг хэдий ч хүчирхийллийн улмаас эрүүл мэндэд учруулсан хор уршиг, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн эдийн засагт учруулах нөлөөллийг тооцох чиглэлээр хийсэн судалгаа хомс байна.

“Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь эмэгтэйчүүд, хүүхдүүд, гэр бүл, цаашид нийгэм, улс үндэстнийг ядууралд хүргэх аюултай. Учир нь хүчирхийллийн хохирогч болсон хүмүүсийн зүгээс гэр бүл, нийгэм, эдийн засаг, улс орны амьдралд оруулах хувь нэмэр хөдөлмөрийн бүтээмж буурч, улмаар нийгмийн халамж үйлчилгээ, шүүх цагдаа, эрүүл мэндийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ. Тэдний мэдлэг боловсрол, бүтээлч шинийг санаачлах идэвх буурах төдийгүй тэдний үр хүүхдүүд ч тэдэнтэй адил байдалд ордог”<sup>1</sup>. Гэр бүл дэх эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл нь “...тухайн эмэгтэй гэр бүлийн хүрээнд төрсөн цагаасаа эхлэн өглөх хүртлээ өөрийн амьдралын орчинд амсаж болох хүчирхийллийн хэлбэр юм. Эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн хамгийн түгээмэл тохиолддог хэлбэрт: зодох,

<sup>1</sup> Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийн талаарх гүнзгийрүүлсэн судалгаа. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 61-р чуулган Урьдчилсан жагсаалтын 60-р зүйл/а/ -ХЭҮК, НҮБХХ., Улаанбаатар, 2007 он., X-53

хамтран амьдрагчийн зүгээс хүчирхийлж байгаа бусад хэлбэр, хүчиндэх, бэлгийн хүчирхийлэл, инжтэй холбоотой хүчирхийлэл, эмэгтэйчүүд, нялхсын амь насыг бүрэлгэх, өрхийн эмэгтэй хүүхдийг хүчирхийлэх... хамтран амьдрагч бусад хүмүүсийн зүгээс үйлдэгдэх хүчирхийлэл”<sup>2</sup> юм. Хэдийгээр гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн гишүүд хооронд гардаг хувийн шинжтэй харилцаа мэт боловч нийгмийн олон асуудалтай харилцан хамааралтай, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, хор уршиг ихтэй нийгмийн асуудал юм. Тиймээс гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын эрүүл мэндэд учирсан хор уршиг, эдийн засгийн өртгийг судалж, түүний бодит хор хохирол, өртөг зардлыг мөнгөн дүнд шилжүүлэн тооцох, шалтгаан, үр дагаврыг тодорхойлох зорилгоор гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн бодит байдал тулгуурлан энэхүү дүн шинжилгээг хийсэн юм.

Судалгаа нь хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүд, гэр бүлд учирч байгаа хор хөнөөлийг ил гарган тавьснаар хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, устгахад бүх нийтийн анхаарлыг хандуулах, иргэд олон нийтийг оролцуулах, төрийн үүрэг хариуцлагыг биелүүлэх арга замуудыг тодорхойлох, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль болон “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг илүү тогтвортой, үр дүнтэй болгох зорьсон билээ.

<sup>2</sup> Мөн судалгаа, Х-39.

## СУДАЛГААНЫ ХҮРЭЭ

Судалгаанд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нийт 125 эмэгтэй оролцсоноос Улаанбаатар хотоос 17,6%, сумын төвөөс 4,8%, аймгийн төвөөс 77,6% байна. Эдгээр эмэгтэйчүүдийн 4,8% нь 18-24 насны, 5,6% нь 25-29 насны, 24% нь 30-34 насны, 38,4% нь 35-44 насны, 25,6% нь 45-54 насны, 1,6% нь 60-с дээш насны эмэгтэйчүүд байв.

## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Гэр бүлийн хүчирхийллийн нийгэм, эдийн засгийн өртгийг судлан тооцоолж, түүний цар хэмжээ, бодит түвшинд дүн шинжилгээ хийж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар бодлогын дүгнэлт, зөвлөмж боловсруулан гаргах нь судалгааны үндсэн зорилго мөн.

Судалгаа нь дараах зорилтуудыг хангана. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдлыг тодорхойлох, түүний шалтгаан, үр дагавар, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн нөхцөл байдал зэргийг танин мэдэх
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас учирсан нийгэм, эдийн засгийн өртөг зардлыг тодорхойлох
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд учирсан хор хөнөөлийн өртөг зардлыг тодорхойлох
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчны тулгамдаж буй зарим асуудлыг тодорхойлох

## СУДАЛГААНЫ ОБЪЕКТ

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг судалгааны объектоор сонгон авсан болно.

## СУДАЛГААНЫ АРГУУД

Баримт бичгийн судалгаа, Анкет сурвалжлагын арга, Экспертийн сурвалжлага, Бүлгийн хэлэлцүүлэг, Ганцаарчилсан сурвалжлага, Кейс судлал

## СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ


Судалгааны түүвэр нь ерөнхийдөө тоон болон чанарын судалгааны гэсэн хоёр төрөлд хуваагдана. Тоон судалгааны түүвэр нь анкет-сурвалжлагын аргаар явуулах судалгааны хүрээнд хамрагдах хүмүүс ба нэгжийн тоо хэмжээ бүтцийг, харин чанарын судалгааны түүвэр нь ганцаарчилсан ярилцлага, кейс судлал болон бүлгийн хэлэлцүүлэгт хамрагдах хүмүүсийн хэмжээ, бүтцийг тус тус харуулна.

		Анкет	Эксперт	Кейс	Фокус
1	Улаанбаатар	25	3	4	-
2	Завхан	50	10	1	1
3	Өмнөговь	50	10	1	1
4	Нийт	125			

ХҮСНЭГТ 1. Судалгааны түүвэр /аймаг, хотоор/

## 1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН БАЙДАЛ

### Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт



Судалгаанд оролцогчдын 39,3% нь аливаа төрлийн дарамт шахалтыг гэр бүлийн хүчирхийлэл гэж үздэгээ илэрхийлсэн.

ЗУРАГ 1. Хүчирхийллийг ойлгох байдал

### ШИГТГЭЭ 1

*Нөхөр таань намайг байнгын шаналгаатай байдалд байлгадаг нь надад маш их даралттай байдаг. Сэтгэл санаагаар даралтлуулж байгаа учраас би өөрийгөө хүчирхийлэлд өртөж байна гэж бодож байна.*

*Ганцаарчилсан ярилцлага. Завхан айтаг.*

Гэр бүл дэх хүчирхийлэл нь гэр бүлийн гишүүд, түүний дотор эмэгтэйчүүд, хүүхдийн амьд явах, аюулгүй байх, бие сэтгэл, эрүүл мэндийн хувьд эрүүл явах, боловсрол ажил, орон байртай байх, нийгэм олон нийтийн үйл хэрэгт оролцох зэрэг үндсэн эрх, эрх чөлөөг нь ноцтойгоор зөрчиж байна. Үүнээс болж эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, сайн сайхан амьдрахад нөхөгдөшгүй гарз хохирол учирч, эдийн засгийн зардал чирэгдэл ихсэж байна.

### Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан, нөлөөлөгч хүчин зүйлс, үр дагавар

Судалгаанд оролцсон 35-54 насны эмэгтэйчүүдийн 68,5% нь архидалтыг хүчирхийлэлд нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйлсийн нэг гэж үзжээ. Нийгэмд түгээмэл тархсан уг сөрөг үзэгдэл гэр бүлийн сайн сайхан байдалд асар ихээр нөлөөлж байгаа нь үүнээс харагдаж байна. Энэ нь цаашдаа архидалт болон гэр бүлийн хүчирхийллийн харилцан хамаарлыг нарийвчлан судлах шаардлагатайг илэрхийлж байна. Судалгаанд оролцогчдын 30.5% нь эрүүл мэндээрээ, 22.4% нь сэтгэл санаагаараа, 17.9% нь санхүүгийн хувьд хохирсон гэж үзсэн нь гэр бүлийн хүчирхийллийн үр дагавар эмэгтэйчүүдэд хамгийн хүндээр тусч байгааг харууллаа.

**Хүчирхийлэлд өртсөн хугацаа, байршил, хүчирхийлэлтэй харилцаанд амьдарсан жил**

Судалгаанд оролцсон таван эмэгтэйн хоёр нь хүчирхийлэлтэй харилцаанд 1-3 жил, 7 эмэгтэйн нэг нь 7-10 жил амьдарч байгаагаар илэрхийлжээ. Энэ нь уг үзэгдэл нуугдмал далд, давтагдсан шинжтэй гэдгийг тодорхойлж байгаа үзүүлэлт юм. Тэдний 83,0% нь 30-54 насныхан, 17,0% хувь нь 18-24 насныхан байна. Судалгаанд оролцогчдын 92,0 % нь гэр бүлийн хүчирхийллийг гэр орондоо болдог гэж хариулжээ. Ийнхүү хариулсан хүмүүсийн 35,1% нь дээд боловсролтой хүмүүс байна. Эмэгтэйчүүдийн талаас илүү хувь /55,6%/ нь оройн цагаар, 5 эмэгтэйн нэг нь өдрийн цагаар гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг цагийг тодруулахдаа бид өглөө, өдөр, орой, шөнө гэсэн 4 хувилбараар хариулт авсан хэдий ч судалгаанд оролцогчдын 13,7% нь “хэзээ л бол хэзээ” гэж хариулсан байна.

### Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр

Гэр орны хүрээнд гэр бүлийн гишүүд хүчирхийллийн олон янзын хэлбэрт өртдөг байна. Гэр бүлийн хүчирхийлэл ерөнхийдөө бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн хэлбэртэй байж болно.<sup>3</sup> Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн хариултыг хамгийн их тохиолддоогоос нь бага руу нь эрэмбэлэхэд дараах дүр зураг гарч байна. Үүнд сэтгэл санааны хүчирхийлэлд эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь өртөж байхад бараг гурван эмэгтэйн нэг нь зодуулж байна. Өөрөөр хэлбэл, сэтгэл санааны хүчирхийлэл нь хамгийн түгээмэл хэлбэр болж байгаа бөгөөд бусад бүх хэлбэрүүдэд дагалдаж байна. Мөн бие махбодын хүчирхийлэл сэтгэл санаанд дарамт үүсгэдэг байна. Бодит амьдрал дээр эдгээр хэлбэрүүд нь ихэвчлэн холимог байдлаар илэрч байна. Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 119 буюу 95,2% нь бие махбодын хүчирхийлэлд сүүлийн нэг жилийн хугацаанд өртсөнөө илэрхийлснээс үзэхэд энэ хэлбэрийн хүчирхийлэл өргөн тархацтай байгааг харуулж байна.

### Бие махбодын хүчирхийлэлд өртсөн давтамж

Давтамж	Тоо	Хувь
7 хоногт 1 удаа	36	30.3
сард 1 удаа	33	27.7
3 сард 1 удаа	16	13.4
6 сард 1 удаа	13	10.9
жилд 1 удаа	8	6.7
амьдралдаа 1 удаа	13	10.9
	119	100.0

ХҮСНЭГТ 2. Хүчирхийллийн давтамж

Бие махбодын хүчирхийлэлд өртөж байгааг ерөнхийд нь байнга болон хааяа гэж ангилж болохоор байна. Зодох үйлдлийн хамгийн өндөр давтамж нь 7 хоногт 1 удаа /30.3%/ , удаах нь сард 1 удаа /27.7%/ -д оногдож байна. Өөрөөр хэлбэл, эдгээр эмэгтэйчүүд нь жилд 12-48 удаа буюу байнга зодуулж байгаагаар илэрхийлсэн нь энэ юм. Харин бусад давтамжууд болох 3 сард 1 удаа, 6 сард 1 удаа, жилд 1 удаа, амьдралдаа 1 удаа зоддог үйлдэл нь харьцангуй ойролцоо, өөрөөр хэлбэл 6,7%-13,4%-

<sup>3</sup> Бие махбодын хүчирхийлэл гэдэг нь хэн нэг нь нөгөөдөө өөрийн хүсэл сонирхол, эрх мэдлээ тогтоох зорилгоор биед нь хүч хэрэглэн халдахыг хэлнэ. Сэтгэл санааны хүчирхийлэл гэдэг нь хэн нэг нь нөгөөдөө өөрийн хүсэл эрмэлзэл, итгэл найдварыг мохоох, сүрдүүлэх зорилгоор хэл ам, үг яриагаар дарамтлахыг хэлнэ. Эдийн засгийн хүчирхийлэл гэдэг нь хэн нэг нь нөгөөдөө өөрийн эрхшээлдээ байлгах зорилгоор эдийн засгийн боломжийг нь хязгаарлаж, хамааралдаа оруулах аргыг хэлнэ. Бэлгийн харилцааны хүчирхийлэл гэдэг нь хэн нэг нь нөгөө хүний халдасгүй, хүсээгүй, бэлэн бус, хүчгүй байдлыг үл хүндэтгэн хүчээр эсвэл хууран мэхлэх, айлган сүрдүүлэх, гүтгэх, доромжлох, дарамт шахалт үзүүлэх г.м аргаар хүчиндэх болон хүчиндэхээр завдохыг хэлнэ. Эх сурвалж: ХЭҮТ “Жендер гэр бүлийн харилцаанд нөлөөлөх нь” УБ., 2005.



ийн тархалттай байна. Энэ нь жилд 1-4 удаа буюу хааяа зодуулдаг ба нийт зодуулж буй эмэгтэйчүүдийн тавны нэг нь байна. Гэр бүлийн хүчирхийллийн давтамж ойртох тусам улам хэрцгий шинжтэй болдгийг судалгаанд оролцогчид илэрхийлж байв.

## ШИГТГЭЭ 2

*Залуудаа танай хүн надад гар хүрэхдээ алгадаад авах хэтжээний л байсан. Хөгширсөн хойноо буруу зөнөж байгаа юмуу бүү тэд гэттэж бэрттэл зодох болоод байна.*

*Ганцаарчилсан ярилцлага. Завхан айтаг*

## 2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРДАЛ

Судалгаанд оролцсон нийт 125 эмэгтэйн 88 буюу 70,4% нь ажил алба болон эд хөрөнгөтэй холбоотой хохирол амссан байна. Бид судалгаандаа гэр бүлийн хүчирхийллийн нийгэмд буюу макро түвшинд учруулж буй үр дагаврын тухай бус харин хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд буюу бичил орчинд учруулж байгаа хэр уршиг үр дагаврын талаар нягтлахыг зорьсон билээ.

д/д	Үчирсан үр дагавар	Хариултын тоо	Эзлэх хувь
1.	эрүүл мэндээрээ хохирсон	68	30,5
2.	санхүүгийн хувьд хохирсон	40	17,9
3.	ажил төрөлгүй болсон	5	2,2
4.	гэр бүл салсан	23	10,3
5.	сэтгэцийн хямралд орсон	50	22,4
6.	нөхөр ял шийтгэл хүлээсэн	12	5,4
7.	найз нөхөд, хамт олноосоо хөндийрсөн	12	5,4
8.	сургууль соёлд явж чадахаа больсон	3	1,3
9.	амиа хорлочихмоор үе байсан	7	3,1
10.	үр хүүхэд хохирсон	8	3,6
11.	бусад	5	2,2
	Нийт	223	100


ХҮСНЭГТ 3. Хүчирхийллээс үчирч буй үр дагавар

Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 30.5 % нь эрүүл мэндээрээ хохирч, 22.4% нь сэтгэцийн хямралд орж, 17.9 % нь санхүүгийн хувьд хохирсон нь хүчирхийллийн үр дагавар эмэгтэйчүүдэд хамгийн хүндээр тусч байгааг харуулж байна. 2002 онд ХЭҮТ-өөс гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар олон нийтээс авсан судалгаа

эдийн засаг, эрүүл мэндээрээ хохирдог гэж 11 орчим хувь<sup>4</sup> нь үзсэнээс харахад хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн өөрсдийн нь хариулт олон нийтийн үзэл бодлоос даруй 37 пунктээр ялгаатай байгаа юм. Өөрөөр хэлбэл хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд эрүүл мэнд, эдийн засгийн үр дагавартаа илүү сэтгэл эмзэглэж байхад олон нийт гэр бүл салалт, хүүхдийн боловсрол, хүмүүжлийн асуудалд илүүтэй санаа зовниж байдаг нь харагдаж байлаа. Харин сэтгэл санааны хямралд ордог гэж эмэгтэйчүүд /22,4%/ болон олон нийт /23%/ адил төсөөтэй хариулснаас харахад энэ нь гэр бүлийн хүчирхийллийн зайлшгүй үр дагавар гэдэгтэй аль аль нь санал нийлж байгааг харуулж байна.

### Гэр бүлийн хүчирхийллийн хохирол, түүний төрлүүд

Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 28,8% нь гэр бүлийн хүчирхийлэл, дарамтаас болж ажилдаа тодорхой хугацаагаар явж чадаагүй гэжээ. Уг эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь нэг удаагийн ажилдаа яваагүйн улмаас 1500-10000 төгрөгийн орлогоо алдсан байхад тавны нэг нь 11000-57500 төгрөгөө алджээ. Энэ хохирол нь нийтдээ 1.882.850 төгрөг болж байгаа бөгөөд нэг удаагийн ажил таслалтаар дунджаар 52.301 төгрөг алдсан байна.



ЗУРАГ 2 Гэр бүлийн хүчирхийллийн хохирол, түүний төрлүүд

Гэр бүлийн хүчирхийллийн ноцтой үр дагаврын нэгийг ажлаасаа халагдах явдал гэж судалгаанд оролцогчид үзжээ. Судалгаанд оролцогчдоос сүүлийн нэг жилд 5 хүн буюу 3.2% нь ажлаасаа халагдсан байгаагаас нэг удаа халагдсан 1, хоёр удаа халагдсан 3, гурван удаа халагдсан 1 эмэгтэй байна. Эл эмэгтэйчүүдийн алдсан хохирол 2.150.000 төгрөг болж байгаа бөгөөд нэг удаа ажлаас халагдахад дунджаар 430.000 төгрөг алдсан байна.

### ШИГТГЭЭ 3

*Нөхөртөө зодуулж даралтлуулснаас болж ажилдаа сэтгэлээсээ хандаж чадахгүй байгааг ажлынхан таань анзаарч, албан тушаал буурч, үүнийг дагаад цалин ч буурсан. Уг нь ахлах инженер байсан ба 450.000 төгрөгийн цалин авдаг байж байгаад өөр ажилд томилогдсоноос хойш 200.000 төгрөг авдаг болсон.*

*Ганцаарчилсан ярилцлага. Завхан айтаг*

<sup>4</sup> Гэр бүлийн хүчирхийллийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэг, хандлага. Судалгааны тайлан. ХЭҮТ, УБ., 2002.

Судалгаанд оролцогчдын 9,6% нь хувиараа эрхэлдэг ажлаа хийж чадахаа больжээ. Эмэгтэйчүүдийн гэртээ захиалгаар оёдол эрхлэх, ТҮЦ ажиллуулах, худалдаа наймаа хийх г.м хувиараа эрхлэх ажлыг сүүлийн нэг жилд 1-30 удаа 75%, 30-с дээш удаа 25% тасалдуулсан байна. Үүнээс 889.500 төгрөгийн хохирол амсаж, зөвхөн нэг удаагийн тохиолдлоор 80.863 төгрөг алдсан байна.

Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 8 хүн тутмын нэг буюу 12% нь мөнгөн хуримтлалаа гэр бүлийн хүчирхийллийн үр дагаврыг арилгахад зарцуулжээ. Зөвхөн сүүлийн нэг жилд хуримтлуулсан мөнгөө нэг удаа алдсан тохиолдол 86,7%, 2-4 удаа алдсан тохиолдол 6,7%, 5-10 удаа алдсан тохиолдол 6,7%-ийг тус тус эзэлж байна. Үүнийг тооцож үзвэл нийтдээ 6.440.000 төгрөг болж байгаа бөгөөд нэг удаагийн зарцуулалтаар дунджаар 429.333 төгрөг алдсан байна.


Эд хогшлоо эвдэн сүйтгэх явдал гэр бүлийн хүчирхийллийн хамгийн элбэг тохиолддог үр дагавар байдаг байна. Сүүлийн нэг жилийн хугацаанд судалгаанд оролцогчдоос 52 эмэгтэй буюу 41,6% нь эд хөрөнгөө сүйтгүүлжээ. 48,1% нь 1-2 удаа, 23,1% нь 3 удаа, 28,7% нь 4-өөс дээш удаа эд хогшлоо сүйтгүүлж эд материалын болон сэтгэл санааны хохирлыг амсжээ. Үүний хохирлыг тооцвол 8.087.100 төгрөг болж байгаа бөгөөд нэг удаа дунджаар 155.521 төгрөг алджээ.

Нөхөр нь эд хогшлоо эвдэн сүйтгэхээс гадна эд хогшлоо зарж үрэх эсвэл зээл авах мэтээр гэр бүлийн төсвийг танадаг тохиолдолтой судалгаанд оролцогчдын 4% буюу 5 хүнд тулгарч, 1-5 удаагийн давтамжтайгаар нийт 2.348.000 төгрөгийн хохирол амсчээ.

#### ШИГТГЭЭ 4

*Нөхөр архи уухаараа агсат тавьж хавь орчиндоо байгаа амьтай, амьгүй бүх зүйл рүү дайрч хүйс тэлтрэнэ гэж орилж ширээ сандал балбаж, аяга таваг шидэлж цонх хагалсан. Үүний хохирол 40-50 мянган төгрөг болсон. Гэрт байгаа өнгө өөдтэй бүхнийг эвдэлж хэтхэлсэн. Зурагт унагаж хагалсан. Үүнийг тухайн үедээ 150 мянган төгрөгөөр авч байсан юм.*

*Ганцаарчилсан ярилцлага. Улаанбаатар хот.*



ЗУРАГ 3. Бичиг баримт устгахад гарсан хохирол /төгрөгөөр/

Судалгаанд оролцогчдын 7,2% нь баримт бичгүүдээ уруулах, шатаалгах зэргээр устгуулдаг болохоо өгүүлж байлаа. Сүүлийн нэг жилд бичиг баримтаа устгуулсан эмэгтэйчүүдийн 66,7% нь нэг удаа, 22,2% нь 2 удаа, 0,8 хувь нь гурван удаа энэ төрлийн халдлагад өртжээ. Баримт бичгээ устгуулснаар 1.123.000 төгрөгийн хохирол учирчээ.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 18.4% нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас хувцсаа уруулж, эдэлж хэрэглэж байсан зүйлээ эвдлүүлсэн байна. Хувцсаа уруулсан эмэгтэйчүүдийн тал шахам хувь нь нэг удаа, 21,7% нь 2-3 удаа, 21,7% нь 4-5 удаа, 8,7% нь 10-аас дээш удаа хувцсаа уруулсан байна. Эмэгтэйчүүд уруулсан хувцасныхаа өртгийг 11000-57500 төгрөг гэж нь үзсэн нь хамгийн өндөр хувийг /61,9%/ эзэлж байна. Үүнээс нийт хохирлыг тооцвол 1.423.000 төгрөг болж байгаа бөгөөд хувцасны үнэ цэнэ, төрөл хэлбэрээс хамааран нэг удаагийн үйлдлээр дунджаар 67.761 төгрөгийн хохирол учирсан байна.

Судалгаанд хамрагдсан нийт хүмүүст сүүлийн нэг жилд учирсан ажил алба, эд хөрөнгөтэй холбоотой хохирлыг багцлан мөнгөн дүнгээр тооцон гаргавал

	Учирсан хохирол	Мөнгөн дүн /төг/	Тоо	Хувь	Дунджаар амссан хохирол
1.	Ажлаасаа халагдсан	2.150.000	5	4	430.000
2.	Ажилдаа тодорхой хугацаанд яваагүй	1.882.850	36	28,8	52.301
3.	Хувиараа эрхэлдэг ажлаа хийж чадахаа больсон	889.500	12	9,6	80.863
4.	Хуримтлалгүй болсон	6.440.000	15	12	429.333
5.	Эд хогшил сүйтгэгдсэн	8.087.100	52	41,6	155.521
6.	Баримт бичиг устгагдсан	1.123.000	9	7,2	160.128
7.	Хувцас хунар урсан	1.423.000	23	18,4	67.761
8.	Нөхөр бусдын нэр дээр хөрөнгө шилжүүлсэн	0	0	0	0
9.	Бусад	2.348.000	5	4	469.600
<b>Нийлбэр дүн</b>		<b>24.343.450</b>	<b>100</b>		

ХТЭСЭГТ 4. Гарсан зардал/ төгрөгөөр

Судалгаанд оролцсон нийт эмэгтэйчүүдийн 70,4% буюу 88 хүн ажил алба, эд хөрөнгөтэй холбоотой хохирол амссан бөгөөд үүнийг тооцож үзвэл зөвхөн нэг жилд 24.343.450 төгрөгийн алдагдалд оржээ.

Гэр бүлийн хүчирхийллийн хамгийн элбэг тохиолддог үр дагаврын нэг нь гэрээсээ хөөгдөж гадуур хоноглох явдал юм байна. Судалгаанд оролцогсдын 76%-д нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэр орноосоо хөөгдөн, гадуур хоноглох явдал тохиолдсон байна. Нийт эмэгтэйчүүдийн 52,8% нь сүүлийн нэг жилд бусдын орон гэрт хоногдсон ба тэдний 68,2% нь 1-7 хоног толгой хоргоджээ. Тэдний ихэнх нь буюу 63,9% нь гэрт амьдардаг бөгөөд өрхийн орлого нь 51000-100000 төгрөг байдаг аж.

Улаанбаатар хотод ХЭҮТ-ийн хамгаалах байранд үйлчлүүлж байсан эмэгтэйчүүдээс судалгаа авахад 89,5% нь 1-7 хоног байрлаж байсан. Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал, эрсдлийн зэргээс хамааран эмэгтэйчүүд харилцан адилгүй хоногоор хамгаалах байранд байрладаг байна. Тэдний 61,5% нь нэг удаа,


38,5% нь хоёроос дээш удаа үйлчлүүлж байгаа аж. Судалгаанд оролцогсдын 5,6% нь зочид буудалд байрлаж байсан бол өрөө байр түрээсэлсэн болон цагдаагийн түр саатуулах байранд тус бүр нэг эмэгтэй байсан нь мөн л 1-7 хоног болжээ. Харин эмэгтэйчүүдийн 5,6% нь байрны орцонд, өөрийн пин амбаарт, гадаа гудамжинд хоног төөрүүлсэн байна. Зарим эмэгтэйчүүд нөхрөө агсам тавиад эхлэхээр нь гэрээсээ гарч яваад унтсаны дараа орж ирдэг тухайгаа өгүүлж байлаа. Ийнхүү нэг талаар эмэгтэйчүүд, хүүхэд аюулгүй орон байраар хангагдах эрхээ эдэлж чадахгүй байгаагаас гадна орон байрны хэрэгцээнээс шалтгаалан хүчирхийллийг даван туулах сонголтгүй болж, мухардалд ороход хүргэдэг байна.

## ШИГТГЭЭ 5

*... Надад айлгийн төв дээр ах дүү, төрөл төрөгсөд байхгүй. Би 3 хүүхдийнхээ хамт хөхөө өвлийн хүйтэнд хөөгдөж гараад очих газаргүй гадаа хоносон. Хүүхдүүдээ байнга хөдөлгөөнтэй байлгаж, дөвхүүлж хоносон. Хичнээн үстэй дээлтэй байсан ч өвлийн шөнийг арай гэж өнгөрүүлсэн. Олон удаа гэрээсээ хөөгдөж байсан. Одоо би нөхрөөсөө салсан. Манай ажлынхан айлын хажуу өрөө хөлслөхөд тусалсан.*

*Ганцаарчилсан ярилцлага. Өтнөговь аймаг.*

Эмэгтэйчүүдийн 73,8% нь бусдын орон гэрт 1-7 хоног толгой хоргодоход ихэвчлэн 1000-10000 төгрөг, 55% нь хамгаалах байранд 11000-40000 төгрөг<sup>5</sup>, 51% нь зочид буудалд 11000-70000 төгрөг, 75% нь өрөө, байр түрээслэхэд хэдэн удаагаасаа хамаараад 11000-100000 төгрөг, цагдаагийн түр саатуулах байранд 22500 төгрөг, байрны орцонд, гадаа гудамжинд хоног төөрүүлэхэд 1000-50000 төгрөг зарцуулсан байна. Судалгаанд оролцогчдын 2,4% нь 3-6 сар, 1,6% нь 1 жилээс дээш бусдын гэр оронд байрлаж байсан юм. Сүүлийн нэг жилд гэр бүлийн хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүд үр хүүхдийнхээ хамт гэрээсээ хөөгдөж гадуур хоноглоход нийтдээ 5.459.100 төгрөгийн зардал гарчээ.



ЗУРАГ 4. Гэрээсээ гадуур хоноглоход гарсан зардал /төгрөгөөр /

Судалгаанд оролцогчдоос гэр бүлийн хүчирхийлэлд өртсөнөөр нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдаж чадсан эсэхийг асуухад 85,6% нь үгүй, 14,4% нь тийм гэж хариулжээ. 2005 онд батлагдан хэрэгжиж байгаа Нийгмийн халамжийн хуулийн дагуу хүчирхийлэлд өртсөн иргэн анх удаа нийгмийн халамж хүртэх эрхтэй хүмүүсийн тоонд багтаж, нөхөн сэргээх, сэтгэл засал болон түр байрлуулах асрамжлах зэрэг халамжийн үйлчилгээний шинэ төрлүүдийг тодорхойлсон. Гэтэл


<sup>5</sup> Энэхүү зардал нь зөвхөн эмэгтэйчүүдийн халааснаас гарч байгаа мөнгөн дүн юм. Үүнд ХЭҮТ-ийн хамгаалах байрнаас гаргаж буй зардлууд ороогүй болно.

судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй байгаа нь тус хуулийн хэрэгжүүлэгч мэргэжилтнүүд уламжлалт үйлчилгээнүүдэд анхаарлаа хандуулсан хэвээр байгааг харуулж байна. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадсан хүмүүс мөнгөн тэтгэмж, тусламж авах, сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө авах, хамгаалах байранд байрлах, сайн дурынхны тусламж дэмжлэг авах, хороо хориноос дэмжлэг авах зэрэг туслалцааг хүртсэн тухайгаа илэрхийлсэн байна.

## ШИГТГЭЭ 6

*Гэр бүлийн хүчирхийлэлд өртөөд олон жил болж байна. Архи ууж агсат тавихаараа зодож дарамтталдаг. Хүүхдүүд таань цагдаа дуудаж барилдаг болохоос өөр ямар ч дэтжлэг тусламж, зөвлөгөө авч үзээгүй. Манай аймагт гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүнд тусладаг байгууллага байхгүй.*

*Ганцаарчилсан ярилцлага. Өмнөговь аймаг.*



ЗУРАГ 5. Нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдсан бийдэл, төрлөөр

Ямар төрлийн үйлчилгээнд хамрагдсаныг давхардсан тоогоор аваад үзвэл 87% нь сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө авсан байхад, дөнгөж 13% нь бусад төрлийн үйлчилгээнд хамрагдсан байна. Судалгаанд оролцсон нийт эмэгтэйчүүдийн 14,4% нь нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдсан бөгөөд үүнийг тооцож үзвэл зөвхөн нэг жилд 598026 төгрөгийн зардал гаргажээ.

Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 95% нь **бусадтай харилцах харилцаандаа өөрчлөлт орсон** гэж үзсэн байна. Тухайлбал, хүчирхийлэлд өртсөн гурван эмэгтэй тутмын нэг нь найз нөхдөөсөө холбоо тасарсан, дөрвөн эмэгтэй тутмын нэг нь айл саахалтынхнаасаа ичдэг болсон, таван эмэгтэй тутмын нэг нь төрөл төрөгсдөөсөө хөндийрсэн байна.

Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн **85,6% нь өөрийнхөө аюулгүй байдлыг алдагдсан** гэж үзэж байхад 14,4% нь алдагдаагүй гэж хариулжээ. Алдагдсан гэж үзэж байгаа шалтгааныг гурван эмэгтэй тутмын нэг нь сэтгэл санааны дарамтанд тайван бус нөхцөлд амьдарч байгаагаар илэрхийлсэн бол 60 шахам хувь нь амь насаа алдах, бие эрхтэн бэртэж гэмтэх өндөр магадлалтай гэж үзсэн байна.

Судалгаанд оролцогчдын үзсэнээр гэр бүлийн хүчирхийллийн 92% нь гэр орондоо үйдэгдэж, хоёр тохиолдол тутмын нэг нь хүүхдийн нүдэн дээр болж, хүүхэд өөрөө өртөөд зогсохгүй хүчирхийллийн гэрч болж байдаг байна. Эмэгтэйчүүдийн 39,8% нь гэр бүлийн хүчирхийлэл нь хүүхдийг сэтгэл зүйн дарамт, гутралд оруулахаас гадна гэрээсээ дайжих, гадуур тэнэх зэрэг сөрөг үр дагавар үзүүлсэн ба хэний

ч үгийг тоохоо болих, хараалын үг хэрэглэх, бусдыг хайрлахаа болих, сурлага, хүмүүжил, идэвх дордоход хүргээд зогсохгүй гэмт хэрэгт орооцолдох нөхцлийг бүрдүүлж өгдөг гэсэн байна.

### ШИГТГЭЭ 7


*Манай нөхөр олон жил архи ууж намайг зодож даратталдаг байсан. Манайх 3 хүүхэдтэй. Нөхөр архи уусаар байгаад 3 жилийн өмнө элэг нь туудаж нас барсан. Төм хүү таань янз бүрийн хүүхдүүдтэй нийлж гадуур их тэнэдэг болсон. Сургуулиа төгсөөд ажил, сургууль ч байхгүй. Хулгай хийж, байнга цагдаагаас дууддаг. Тэр болгонд нь торгууль төлж арай л шоронгүй салгадаг.*

*Ганцаарчилсан ярилцлага. Өтнөгөв аймаг.*

Сүүлийн нэг жилд хүүхэд нь гэмт хэрэгт орооцолдсон гэж судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 1,9% нь хариулсан ба үүнтэй холбоотой гаргасан зардлыг тооцож үзвэл 980.000 төгрөг болж байна.

## 3. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРДАЛ

Бидний судалгааны нэг зорилт нь гэр бүлийн хүчирхийллийн үр дагаврын улмаас эмэгтэйчүүдийн эрүүл мэнд хохирч байгаа асуудалд анхаарлаа хандуулж, түүнд зарцуулсан өртөг зардлыг тооцоолох явдал байсан юм. Эрүүл мэндээрээ хохирсон эмэгтэйчүүдийг насны хувьд аваад үзэхэд 70,5% нь 2-3 хүүхэдтэй, 30-44 насных байлаа.



ЗУРАГ 6. Эрүүл мэндийн хохирол, төрлөөр

**Хөхөрч няцрах, нүүрэндээ шарх сорви авах гэмтлийг** нийт судалгаанд оролцогчдын бараг тал хувь нь амссан байна. Судалгаанд оролцсон 125 эмэгтэйн 7 нь нүүрэндээ шарх сорви авах, хамраа муруйлгах, хөмсгөө задлуулах, бөгжтэй гараар нүд рүүгээ цохиулан хараанд өөрчлөлт орох, шүдээ цөм цохиулах, түлэгдэх г.м гэмтлийг аван гоо сайхны хувьд хохирсон, 54 нь хөхөрч няцарсан гэсэн хариултыг өгсөн байна.

### Сэтгэл санааны хохирол

Хүний сэтгэц эрүүл байна гэдэг нь тухайн хүний бодол санаа, зан үйл, мэдрэхүйн сайн сайхан байдлыг хэлнэ.<sup>6</sup>

<sup>6</sup> ДЭМБ-ын тодорхойлсноор: Сэтгэцийн эрүүл мэнд гэдэг нь хүн сэтгэцийн өвчингүй байхын зэрэгцээ нийгэм болон хүрээлэн байгаа гадаад орчинтойгоо дасан зохицож, хэвийн ажиллах, амьдрах, суралцах, нийгэмд зохих байр сууриа эзлэн хувь нэмрээ оруулж чадах энх амгалан байдлыг хэлнэ.


Гэтэл судалгаанд оролцогсдын 28,3% нь эрүүл мэндийн хувьд янз бүрийн байдлаар хохироод зогсохгүй байнгын сэтгэл санааны дарамтад амьдарч, сэтгэлзүйн хүнд цохилгоос гарах аргаа олохгүй мухардаж байгааг өгүүлсэн. Тэд сэтгэл зүйн хямралт байдалд орсны анхны шинж тэмдэг болох нойргүйдэлд 8.9% нь автсан байлаа. Сэтгэцийн хямрал, нойргүйдлээс гарах арга хэмжээг авч чадахгүйгээс архаг ядаргаанд орох, тайлбарлах боломжгүй биеийн зовиур шаналгаануудтай болсноо эмэгтэйчүүд өгүүлж байв. Сэтгэл зүйн гутрал, нойргүйдлээс гарах эмчилгээнд 110000-200000 төгрөгийн зардал гарган хамрагдсан 2 эмэгтэй, харин нойрны болон тайвшруулах эмэнд 12000 хүртэлх төгрөгийн зардал гаргасан 3 эмэгтэй байлаа.

Судалгаанд оролцсон 76 эмэгтэй өөрсдийнхөө амьдралд гутарч явдгаа илэрхийлсэн. Тэдгээр эмэгтэйчүүдээс 16 нь 110000-200000 төгрөгийн зардал гарган эмчилгээнд хамрагдсан байна.

## ШИГТГЭЭ 8

*Халгийн их гэртсэн нь сэтгэл. Ууртай гомдолттой, хардангүй гээд халгийн жуу бүхнийг сурсан. Сэтгэлийн ялар ч тэнхлэгүй болсон.*

*Ганцаарчилсан ярилцлага, Улаанбаатар хот*



ЗУРАГ 7. Эрүүл мэндэд учирсан хохирол, мөнгөн дүнгээр

Судалгаанд оролцогчдын 35.2% нь эрүүл мэндээрээ хохирон 60000 - аас 250000 хүртэлх төгрөгийг гаргасан байна. Хүчирхийлэлд өртсөнөөр тэд зөвхөн хөхөрч явцрах биш, гоо сайхны талаасаа хохирох төдийгүй сэтгэлзүйн шарх авах, суурь өвчтэй болох г.м олон давхар хохирлыг амсдаг нь давхардсан тоогоор 184 хариулт ирснээс харж болох юм. Уг хариултыг эрүүл мэндийн хувьд хохирол амссан гэж хариулсан 122 эмэгтэйн тоотой харьцуулахад нэг эмэгтэй доод тал нь 2-оос доошгүй төрөлд хохирол амсдаг нь харагдаж байна.

№	Төрөл	Хариултын тоо	Нэг хүнд ноогдох дундаж зардал	Нийт зардал
1	Эм тариа худалдаж авсан	79	36937	2918025
2	Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн	10	85059	3997800
3	Оношлогоо эмчилгээ хийлгэсэн	43	66327	2852100
4	Явж эмчлүүлсэн унааны зардал	25	101849	2546230
5	Бариа засал зүү төөнүүр хийлгэсэн	28	5992	167800



6	Амбулаториор эмчлүүлсэн	13	28007	364100
7	Эмнэлгийн яаралтай тусламж авсан	7	40142	281000
8	Хүний асаргаанд орсон	2	115000	230000
9	Бусад	3	15000	45000


ХҮСНЭГТ 5. Эрүүл мэндийн хохирлыг эмчлүүлэхэд гарсан зардал, төрлөөр

Судалгаанд хамрагдсан 125 эмэгтэйн 96 буюу 76,8% нь дээрх үйлчилгээ хийлгэснийг давхардсан тоогоор гаргахад нийтдээ 17.935.900 төгрөг зарцуулсан байгаа бөгөөд нэг хүн дунджаар 186811 төгрөгийн өртөг гарган эмчлүүлжээ. **Эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх, оношлогоо эмчилгээ хийлгэх зардал нь бусад зардалтай харьцуулахад харьцангуй өндөр гарчээ.** Харин хүчирхийлэлд өртсөнөөр зайлшгүй эмнэлгийн болоод дээрх төрлийн үйлчилгээг авах шаардлагатай болсон гэж хариулсан 38,4% буюу 48 эмэгтэйн хариултаас үзэхэд эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн зардал дунджаар 12000-50000 төгрөг байгаа нь хамгийн өндөр, удаах зардал нь явж эмчлүүлсэн унааны зардалд 31000-100000 төгрөг, оношлогоо эмчилгээнд 12000-50000 төгрөг зарцуулсан гэж тус тус хариулсан байна.

### Суурь өвчин, зардал

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд олон дахин хүчирхийлэлд өртсөнөөр удаан хугацааны стресст орон, өөрт гарч ирж байгаа зан үйл, биеийн болон сэтгэцийн өөрчлөлтдөө дасаж, үүсээд байгаа нөхцлөө засаж залруулах чадваргүй болж, улмаар суурь өвчтэй болдог байна.


Судалгаанд оролцсон **94 эмэгтэй буюу 75,2% нь өөрсдийгөө суурь өвчтэй болсноо илэрхийлсэн.** Суурь өвчтэй болсон эмэгтэйчүүдийн 90,4% нь үүнийхэ шалтгааныг бүх төрлийн дарамт шахалтаас болсон, 37,2% нь архи дарстай холбоотой 13,8% нь зодож цохисноос бэртэл гэмтэлтэй болсон, 12,7% нь сэтгэлийн дарамт, бие биенээ үл хүндэтгэх байдал, хардалтаас үүдэлтэй гэж үзсэн байна. Мөн суурь өвчтэй эмэгтэйчүүд хамгийн их зардал гаргадгийг судалгааны дүн харуулсан.



Энэ графикаар дамжуулан өөрсдийгөө суурь өвчтэй болсон гэж өгүүлсэн эмэгтэйчүүдээс хичнээн нь өөрсдийнхөө өвчнийг эмчлүүлэхэд зардал гаргасан бэ гэдгийг судалсан юм. Эндээс үзэхэд **тархи толгой, харах сонсох эрхтний хувьд суурь өвчтэй болсон эмэгтэйчүүдийн тоо, үүнийгээ зардал гарган эмчлүүлсэн гэсэн хариултын тоо бараг тэнцүү байгаа нь тухайн өвчлөл эмэгтэйчүүдэд хурцаар нөлөөлдөг, яаралтай эмчилгээ шаарддаг болохыг үзүүлж байгаа юм.** Үүнд: суурь өвчтэй болсон нийт 94 эмэгтэйн 3 нь харах сонсох эрхтний өвчтэй болсноос гурвуулаа 60000-250000 төгрөг хүртэлх хэмжээний зардал гарган эмчлүүлсэн. Тархи толгойн өвчтэй болсон 26 эмэгтэйгээс 23 нь 110000-250000 төгрөгөөр эмчлүүлсэн байна. Бөөр давсагны өвчтэй болсон гэж 9 эмэгтэй хариулсан байсан ч зардал гарган эмчлүүлсэн нь 2 дахин их байна. Энэ нь зодуулж цохиулснаас, доргилт авснаас суурь өвчтэй болох нь их байгааг илэрхийлж байх талтай. Зүрх, элэг цөс, ходоод гэх мэт дотор эрхтнүүдийн өвчтэй эмэгтэйчүүдийн тоо үүнийгээ эмчлүүлэхэд гаргасан зардал хоёр нилээд зөрөөтэй байгаа нь өвчлөлийнхөө онцлогтой холбоотой гэж үзэж байна.

### Хүчирхийлэлд өртсөний дараах тайтгарал

Стрессыг хугацааны хувьд богино ба урт гэж ангилдаг. Богино хугацаанд дистрессээс ангижрах гэдэгт өөрөө өөрийгөө жолоодохтой холбоотой аргууд байдаг. Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 45,5% нь **хэн нэгэнд асуудлаа ярьдаг, 24.8 % нь буюу тавны нэг нь уйлж сэтгэлээ онгойлгодог гэсэн бол 13.2 % нь архи, тамхи, эмээр бухимдлаа тайлж, тайвширдаг гэсэн байна.**



ЗУРАГ 9. Хүчирхийлэлд өртсөний дараа бухимдлаа тайлдаг аргууд

Дээрх хариултуудаас үзэхэд мэргэжлийн туслалцааг аваагүй байна. Иймээс гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдтэй ажиллах сэтгэл зүйч, эмч, нийгмийн ажилтан зэргийг мэргэшүүлж, удаан хугацааны турш стресстэй байгаа хүмүүст нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээг хийдэг, асуудалд цогц ханддаг болгоход анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

## 4. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдээс “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх туха хууль”-тай танилцсан байдлыг сонирхон үзсэн болно. Ингэж үзэхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн бараг тал хувь нь өнөөдрийг хүртэл эн талаар тусгайлан гаргасан хууль, тогтоомжтой танилцаагүй байгаа нь анхаара татаж байна.

Судалгааны дүнгээс үзэхэд хүчирхийлэлд өртөгчид шаардлагатай үед хуулийн дагуу хамгаалалтад орох, туслалцаа авах, хэргээ нэг мөр шийдвэрлүүлэх хохирлоо барагдуулах зэрэг арга хэмжээнүүдэд сэтгэл ханамж тун доогуу явж байгаа нь харагдаж байна. Үүнийг тоон болон чанарын судалгааны үр дүн тулгуурлан зарим нэг учир шалтгаантай холбон тайлбарлах үүднээс: нэгдүгээр шаардлагатай үед хүчирхийллийг таслан зогсоож чадаж байгаа эсэх/хохирогчий шуурхай хамгаалалтад авах, хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах гэх мэтээр, хоёрдугаарт, хүчирхийлэл үйлдэгчид оногдуулж байгаа хариуцлага нь оновчто байгаа эсэх, гуравдугаарт, хүчирхийллийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүл чадаж байгаа эсэх гэсэн 3 чиглэлд анхаарлаа хандуулсан.

Үндсэн хуулинд заасанчлан иргэн хүн гадны гэмт халдлагаас хамгаалуула эрхтэй. Энэ нь иргэнд аюултай гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, халдлаг гарвал таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээх гэсэн агуулгатай байдаг. Гэ бүлийн хүчирхийлэл далд нууц үйлдэгддэг учраас түүнийг эрт шатанд нь илрүүлэх шуурхай таслан зогсоох нь чухал болно. Гэвч хууль, шүүхийн байгууллагууды арга ажиллагаа, туршлагын өнөөгийн түвшин нь хүчирхийллийг тэр бү шаардлагатай үед нь таслан зогсоож чаддаггүй байна. Хүчирхийллээ хамгаалах хууль, шүүхийн арга хэмжээ нь ихэвчлэн өнгөрсөн борооны хойноос цу нөмрүүлсэн байдлаар явагдаг гэж гэр бүлтэй эмэгтэйчүүдийн 55 орчим хувь нь үзсэ бол, тусдаа амьдарч байгаа эмэгтэйчүүдийн 66 хувь нь, харин салсан эмэгтэйүүдий 80 хувь тус тус ийнхүү хариулсан байна.

	Шалтгаанууд	Давтамж	Хувь
1	Хэнд хандахаа мэдэхгүй	8	12.5
2	Айж ичсэнээс илчилдэггүй	9	14.1
3	Гэр бүлийн асуудлаа хүнд ярих дургүй	18	28.1
4	Үр хүүхдээ боддог	12	18.8
5	Хайртай учраас уучилдаг	1	1.6
6	Хүчирхийллийн дараагийн дарамтаас айдаг	7	10.9
7	Хүчирхийлэл үйлдэгчийг өрөвддөг	4	6.3
8	Хэлээд ч нэмэргүй	5	7.8

ХҮСНЭГТ 6. Хүчирхийллийн үед хуулийн байгууллагад хандаж чаддаггүй шалтгаан

Эмэгтэйчүүдийн бараг тал хувь нь хүчирхийллийн үед хуулийн байгууллагаас туслалцаа авахаар ханддаггүй гэжээ. Энэ нь олон шалтгаантай байдаг агаад гэр бүлийн дотоод асуудал, эмзэг зүйл байдаг учир олонхи нь ийнхүү тусламж авч чаддаггүй байна. Харин хүчирхийлэл үйлдэгчээс айснаас болж, түүний дарамтанд байгаагаас зохих байгууллагад хандаж чаддаггүй гэж 10 эмэгтэй тутмын нэг хариулжээ. Энэ нь хэргийг хянан шийдвэрлэх процесс нь хүчирхийллийн гэрч, хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчийн дарамт, өс хонзонгоос хамгаалах чадваргүй байгааг харуулах баримт мөн юм.


**ШИГТГЭЭ 9**

*Цагдаа дуудаад эрүүлжүүлэхэд өгч болно. Гэвч эргээд л манай гэрийн мөнгөнөөс зардал гарна шүү дээ. Эрүүлжүүлэхийн мөнгө, энэ тэр гээд мөнгө төлж авдаг. Ингэж бодохоор сүүлдээ алуулчихгүй шиг аяыг нь олоод л байж байх бодол төрөх болсон доо.*

*Гэр бүлийн хүчирхийлэлд хохирогчид цагдаад хандахаасаа илүүтэй өөр хүтүүст хандах нь бий. Цагдаад хандахаар торгууль, шийтгэл, хорих саатуулах гээд дараа нь бүх мөнгө төгрөг гэр бүлийн төсвөөс гарч давхар шийтгүүлдэг.*

*Бүлгийн ярилцлага. Өмнөговь аймаг*

Судалгаанд оролцсон нийт эмэгтэйчүүдийн 47,6% нь цагдаа, шүүхийн байгууллагад хандсанаас 44.8% нь цагдаа дуудах, эрүүлжүүлэх, торгууль төлөх, шийтгэл хүлээх, өмгөөлөгч, хууль зүйн туслалцаа, зөвлөгөө авах зэрэг үйлчилгээнд зардал гаргасан байна. Судалгаанд оролцогчдын 66.7% нэг л удаа хууль зүйн туслалцаа, зөвлөгөө, өмгөөлөгч авч үзсэн гэсэн хэрнээ эрүүлжүүлэхийг дуудсан тохиолдол 50 гаруй байлаа.



**ЗУРАГ 10. Цагдаа, хууль шүүхийн байгууллагатай холбоотой гарсан зардал (төгрөгөөр)**


Энэ үйлчилгээг бага авч байгаагийн учир нь зардал өндөр байдагтай холбоотой байж болох юм.

Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн 16.8% цагдаа дуудахад, 8% нь хэрэг үүсгэхэд, 36% нь эрүүлжүүлэхэд, 9.6% торгууль төлөх, шийтгэл хүлээхэд, 5.6% нь өмгөөлөгч, хууль зүйн туслалцаа, зөвлөгөө авахад зардал гаргасан ба нийтдээ 2522700 төгрөг зарцуулжээ.

**Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоож буй байдлаас үзвэл нөхрийг нь эрүүлжүүлэх, цашилбал хэд хоног албадан саатуулах, захиргааны хариуцлага хүлээлгэж баривчлах байдлаар хязгаарлагдаж байна. Эрүүгийн гэмт хэрэг үүсгэн ял шийтгэл оноосон тохиолдол цөөхөн байна.**

Хуулийн хэрэгжилттэй холбоотой анхаарал татаж байгаа дараагийн нэг асуудал нь **хүчирхийллээс хохирсон хохирлыг барагдуулах явдал байна.** Гэмт халдлагын улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх нь хүний үндсэн эрх мөн. Энэ утгаараа эмэгтэйчүүд гэр бүлийн хүчирхийллээс өөртөө учирсан хор, хохирлоо нөхөн төлүүлэх нь шударга ёсонд нийцэх учиртай.

Хохирлоо барагдуулах эрх нь өөрт учирсан хохирлоо үнэн зөв тодорхойлуулах, дараа нь түүнийг бүрэн барагдуулах гэсэн хоёр шаардлагыг агуулдаг. гэр бүлийн хүчирхийллийн хохирлын өртгийг тооцох, түүнийг барагдуулах арга механизм, туршлага байхгүй байгаатай холбоотойгоор эмэгтэйчүүд хохирсон дээрээ хохирч үлдсээр байна. Олон улсын хэмжээнд мөрдөгддөг **“гэр бүлийн хүчирхийллийн үр дагавар, түүний өртөг”** хэмээх нэр томъёо манай эрх зүйн практикт төдийгүй эрдэм судлалын салбарт ч хэрэглэгдээгүй шинэ тулгар байна. Манай одоогийн хуулинд гэр бүлийн хүчирхийллийн өртөг гэсэн ойлголт орж ирээгүй учраас түүнийг тооцоолох, хэрхэн нөхөн барагдуулах тухай зохицуулалт байхгүй байна. **Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн дийлэнхи нь өөртөө учирсан хохирлыг хууль, шүүхийн байгууллага тооцоолж гаргаж чадаагүй** гэж үзэж байна.



ЗУРАГ 11. Хүчирхийллийн улмаас учирсан хохирлыг тооцсон байдал

		Барагдуулж чадаж байна	Зарим талаар барагдуулж байна	Огхон ч барагдуулаагүй	Мэдэхгүй	Нийт
1	Эрүүл мэндэд учирсан хохирлыг	6.1	13.9	60.9	19.1	100
2	Эдийн болон санхүүгийн хохирлыг	2.6	12.0	69.2	16.2	100
3	Сэтгэл санааны хохирлыг	0.8	0.8	83.6	14.8	100
4	Нийгмийн хохирлыг	0.0	5.2	75.9	19.9	100

**ХҮСНЭГТ 7. Хүчирхийллийн улмаас учирсан хохирлыг барагдуулсан байдал**

Гэр бүлийн хүчирхийлэл нь амьдрал дээр янз бүрийн төрөл, хэлбэрээр илэрдэг болохоор тэр хэмжээгээрээ түүнээс учрах хохирол нь янз бүр байна. Иймээс гэр бүлийн хүчирхийллээс учирсан хохирлыг нөхөн барагдуулах асуудлыг цаашид хохирлын төрөл, хэлбэрээр авч үзэж болох юм.

Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувьд өөрсөддөө учирсан аливаа төрлийн хор, хохирлыг барагдуулж чадаагүй гэж үзэж байна.

## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

- Гэр бүлийн хүчирхийлэл нь нэн тулгамдсан асуудал хэвээр байна. Энэ нь хүний эрүүл мэнд, насжилт, хүний хөгжил, нийгмийн идэвх оролцоо, хөдөлмөрийн бүтээмжийг бууруулах, чадварыг алдуулах, амьдралын аюулгүй байдлыг алдагдуулж, хорт зуршилд автуулах, сэтгэл санааны дарамтанд оруулахаас гадна нийгэм улс орны хөгжил, эдийн засагт хор уршиг учруулсаар байна.
- Судалгаанд оролцсон 125 эмэгтэйн сүүлийн нэг жилийн нийт хохирлыг тооцвол 51.839.176 төгрөг болж байгаа бөгөөд нэг хүн дунджаар 414.713 төгрөг зарцуулсан байна.

### Гэр бүлийн хүчирхийллийн ойлголт, нөлөөлөгч хүчин зүйл, хэлбэр, давтамжийн тухайд

Судалгаанд оролцогчдын 39,3% нь аливаа төрлийн дарамт шахалтыг гэр бүлийн хүчирхийлэл гэж үздэгээ илэрхийлсэн. Эмэгтэйчүүдийн 68.5 % нь гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйлийг архидалт гэж үзсэн. Судалгаанд оролцсон таван эмэгтэйн хоёр нь хүчирхийлэлтэй харилцаанд 1-3 жил, 7 эмэгтэйн нэг нь 7-10 жил амьдарч байгаагаа илэрхийлжээ. Энэ нь уг үзэгдэл нуугдмал далд, давтагдсан шинжтэйг харуулж байна. Хүчирхийллийн хэлбэрийн хувьд сэтгэл санааны хүчирхийлэл хамгийн өндөр хувьтай байгаа бөгөөд бие махбодын хүчирхийлэлд хамгийн өндөр давтамжтайгаар өртөж байна.

### Гэр бүлийн хүчирхийллийн нийгэм эдийн засгийн зардлын тухайд

Гэр бүлийн хүчирхийллийн нийгэм-эдийн засгийн өртгийг тооцоход 31.380.576 төгрөг болж байна. Үүнээс:

- Судалгаанд оролцсон нийт эмэгтэйчүүдийн 70,4% /88 хүн/ ажил алба, эд хөрөнгөтэй холбоотой хохирол амссан бөгөөд үүнийг тооцож үзвэл зөвхөн нэг жилд 24.343.450 төгрөгийн алдагдал амссан байна. /Энд ажил хийж байсан бол олох байсан орлогыг тооцож оруулаагүй, шууд гарсан зардлыг тооцсон болно./
- Сүүлийн нэг жилд гэр бүлийн хүчирхийллийн улмаас эмэгтэйчүүдийн 80 гаруй хувь нь үр хүүхдийнхээ хамт гэрээсээ хөөгдөж гадуур хоноглоход нийтдээ 5.459.100 төгрөгийн зардал гарчээ.
- Судалгаанд оролцсон нийт эмэгтэйчүүдийн 14,4% нийгмийн халамж үйлчилгээнд хамрагдсан бөгөөд үүнийг тооцож үзвэл зөвхөн нэг жилд 598.026 төгрөгийн зардал гаргажээ.
- Сүүлийн нэг жилд хүүхэд нь гэмт хэрэгт холбогдсоноос гарсан нийт зардлыг тооцвол 980.000 төгрөг болж байна.

## Гэр бүлийн хүчирхийллийн эрүүл мэндийн зардлын тухайд

Судалгаанд оролцсон 125 эмэгтэйн 69,2 % нь эрүүл мэндийн болон сэтгэл зүйн хувьд хохирол амссаныг давхардсан тоогоор нь гаргахад нийтдээ 17.935.900 төгрөг зарцуулсан байгаа бөгөөд нэг хүн дунджаар 186811 төгрөгийг зарцуулжээ.

- Хөхөрч няцрах гм зөөлөн эдийн гэмтлээс гадна хамраа муруйлгах, хөмсгөө задлуулах, шүдээ цөм цохиулах, түлэгдэх зэргээр нүүрэндээ шарх сорви авсан гэмтлийг судалгаанд оролцсон эмэгтэйчүүдийн бараг тал хувь /49.1 %/ нь амссан байна.
- Судалгаанд оролцсон 125 эмэгтэйгээс 76 нь өөрсдийнхөө амьдралд гутарч явдгаа илэрхийлсэн. Гэвч сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, сэтгэцийн эмч гм мэргэжлийн хүнээс туслалцаа авсан тохиолдол байхгүй байна.
- Гэр бүлийн хүчирхийллийн янз бүрийн хэлбэрт өртсөн эмэгтэйчүүд өвчнөө эмчлүүлэхгүй явснаас болоод суурь өвчтэй болсон хэмээн 96 эмэгтэй буюу 76.8% нь хариулсан нь эрүүл мэндийн бодлого боловсруулагчдын анхаарлыг зүй ёсоор татах асуудал болжээ.
- Гэр бүлийн хүчирхийлэлд нэгэнт өртсөн дээрх эмэгтэйчүүдийн хувьд өвчнөө эмчлүүлэхэд гарч байгаа зардал асар өндөр байгааг анхааралдаа авах шаардлагатай болсон байна. Шаардлагатай гэж хэлж байгаагийн учир эрүүл мэндийн өртгийг дангаараа судалсан судалгаа өмнө нь хийгдэн зардал мөнгө өндөр байгааг гаргасан ч, ямар нэг дорвитой өөрчлөлт эрүүл мэндийн бодлого боловсруулагчдын зүгээс гарахгүй байгаад дүгнэлт хийх цаг болсон байна.

## Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчин, хэрэгжилтийн байдал

Өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжуудад гэр бүлийн хүчирхийллийн өртөг гэсэн ойлголт орж ирээгүй учраас түүнийг тооцоолох, хэрхэн нөхөн барагдуулах тухай зохицуулалт байхгүй байна. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн дийлэнхи нь өөртөө учирсан хохирлыг хууль, шүүхийн байгууллага тооцоолж гаргаж чадаагүй, хохирлыг барагдуулаагүй гэж үзэж байна.

Судалгаанд оролцсон нийт эмэгтэйчүүдийн 47,6% нь цагдаа, шүүхийн байгууллагад хандсанаас 44.8% нь цагдаа дуудах, эрүүлжүүлэх, торгууль төлөх, шийтгэл хүлээх, өмгөөлөгч, хууль зүйн туслалцаа, зөвлөгөө авах зэрэг үйлчилгээнд нийтдээ 2.522.700 төгрөг зарцуулжээ.

- Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдээс “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-тай танилцсан байдлыг сонирхон үзэхэд тэдний гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн бараг тал хувь нь танилцаагүй байна. Энэ нь хариуцлага болон хамгаалалтын шинэ төрлүүдийн талаар мэдээлэлгүй байхад хүргэж, хууль батлагдахаас өмнө хэрэглэж байсан Захиргааны хариуцлагын болон Согтууруулах ундаа албадан хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх хуулиудын дагуу хүчирхийлэл үйлдэгчийг эрүүлжүүлэх, түр саатуулах, баривчлах арга хэмжээнүүдийг хүчирхийлэл үйлдэгчид авахуулах хүсэлт гаргаж, өөрсдөө давхар хохироход хүргэсэн байна.



- УИХ хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих үүргээ хангалтгүй биелүүлж байгаагаас Засгийн газрын зүгээс засаг захиргааны нэгж бүрт тус хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүд болон хуулийн хэлтэс, цагдаагийн байгууллагын нэгж бүтцээр дамжуулан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг өргөн сурталчлах ажлыг системтэйгээр зохион байгуулах ажил хийгдэхгүй байгаа учир хохирогчдын мэдээлэл авах боломж хомс байгаа явдал шууд холбоотой гэж үзэж байна.
- Судалгааны дүнгээс харахад хүчирхийлэлд өртөгчид шаардлагатай үед хуулийн дагуу хамгаалалтад орох, туслалцаа авах, хэргээ нэг мөр шийдвэрлүүлэх, хохирлоо барагдуулах зэрэг арга хэмжээнүүдэд сэтгэл ханамж тун доогуур байгаа нь харагдаж байна. Хуулийн байгууллагаас авч байгаа арга хэмжээ нь “өнгөрсөн борооны хойноос цув нөмрөв” гэгчээр явагддаг гэж гэр бүлтэй эмэгтэйчүүдийн 55 %, тусдаа амьдарч байгаа эмэгтэйчүүдийн 66%, салсан эмэгтэйчүүдийн 80 % нь тус тус үзжээ.
- Судалгаанд оролцсон 10 эмэгтэй тутмын нэг нь хүчирхийлэл үйлдэгчээс айснаас, түүний дарамтанд байгаагаас болж, зохих байгууллагад хандаж чаддаггүй гэж хариулжээ. Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг хянан шийдвэрлэх процесс нь хүчирхийллийн гэрч, хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчийн дарамт, хонзогнолоос хамгаалах чадваргүй байгаагаас эмэгтэйчүүдийн зарим нь хуулийн байгууллагад хандаж чадахгүй байгааг энэ баримт харуулж байна.

### **Судлаачдын баг дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.**

#### **Үүнд:**

- Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдалд үнэлгээ хийх, эрсдэлт болон аюултай нөхцлийг тодорхойлох нэгдсэн шалгуур, аргазүйг боловсруулж, баталгаажуулах
- “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” болон холбогдох хуулиудад “гэр бүлийн хүчирхийллийн өртөг зардал” хэмээх ойлголтыг оруулж өгөх, гэр бүлийн хүчирхийллийн улмаас учирсан хохирлыг барагдуулах талаар тодорхой тусгах, улмаар түүнийг тооцох аргачлалыг Улсын дээд шүүхийн тайлбараар батлан мөрдөх
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирлыг зөвхөн санхүү болон эд материалын хохирлоор хязгаарлахгүйгээр амь нас, сэтгэл санааны хохирлыг тооцох, үнэлэх нэгдсэн аргазүй, стандартыг гаргах, хохирлыг барагдуулах, нөхөн төлүүлэх оновчтой тогтолцоог бий болгох
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хуулийн хамгаалалтыг эдэлснийхээ төлөө давхар хохирч, эрүүлжүүлэх, баривчлах байрны мөнгийг хүчирхийлэл үйлдэгчийн өмнөөс төлж байгаа практикийг халах, хүчирхийлэл үйлдэгчид эдгээр зардал, торгууль гм эдийн засгийн шийтгэлээс илүү зан үйлд нь нөлөөлөх юмуу биечлэн эдлүүлэх хариуцлагыг илүү сонгоход анхаарах

- Өнөөгийн эрхзүйн практик нь гэр бүлийн хүчирхийллийг нэг мөр шийдвэрлэж чадахгүй байна. Хуулийн арга хэмжээ нь хэргийг шийдвэрлэх биш цаашид хохирогчийг илүү хүнд, байнгын, үргэлжилсэн дарамтанд оруулах хандлагатай байна. Үүнийг сайтар харгалзан гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг урт хугацаанд хамгаалах зорилгоор аюулгүй орон байраар хангах хөтөлбөр болон засрахгүй бол хариуцлагыг чангатгах болзолтойгоор хүчирхийлэл үйлдэгчийг зан үйлд нөлөөлөх хөтөлбөрт хамруулах зэрэг үр дүнтэй механизмыг бий болгох
- Цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийллийн дуудлагад тэргүүн ээлжинд очиж үйлчлэх удирдамж батлан мөрдүүлэх, хэв журмын зөрчлийг бүртгэх бүртгэлийг улсын хэмжээнд цахим сүлжээнд холбон бүртгэх, учирсан хохирлыг уг бүртгэлийн маягтанд тусгаж өгөх
- Нийгмийн халамжийн хуульд заагдсан сэтгэл засал гм үйлчилгээний шинэ төрлүүдийг хөгжүүлэх, хамгаалан байрлуулах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэх, улсын төсөвт суулгах
- Гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг хөгжүүлэх, гэр бүлд нийгэм, сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөөг хүргэх үйл ажиллагааг бодлоготойгоор дэмжих, ялангуяа төлбөрийн чадваргүй иргэдэд уг үйлчилгээг хүргэхэд анхаарах
- Засгийн газрын зүгээс засаг захиргааны нэгж бүрт тус Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн мэргэжилтнүүд болон хуулийн хэлтэс, цагдаагийн байгууллагын нэгж бүтцээр дамжуулан тус хуулийг өргөн сурталчлах, хууль хэрэгжүүлэгч мэргэжилтнүүдийн ойлголт, мэдлэг хандлагыг өөрчлөх, мэргэшүүлэх ажлыг тодорхой хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу байнгын, тогтвортой, системтэйгээр зохион байгуулах
- Гэр бүлийн хүчирхийллийг эрт шатанд нь илрүүлэх, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийн мэдээлэх санаачилгыг дэмжих, цагдаагийн байгууллагад хүчирхийллийн гэрч, хохирогчийг хамгаалах тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлэх
- Архидалт болон гэр бүлийн хүчирхийллийн харилцан хамаарлыг нарийвчлан судлах
- Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүчирхийллийн улмаас гэмтэл авах эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, гэмтлийн эмнэлэг болон дүүргийн эмнэлгүүд дээр хүчирхийллийн хохирогчдод үйлчлэх тусгай өрөө гарган ажиллуулах
- Гэмт хэргийн хохирогчдын хохирлыг барагдуулах, нөхөн төлүүлэх бие даасан хуулийг батлуулах, тусгай сан бий болгох